



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 18 сарын 19 өдөр

Дугаар A/788

Арвайхээр

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.17, Засгийн газрын 1997 оны "Аймаг, нийслэлийн засаг даргаас олгох шагналын тухай" 54 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1. Аймгийн Засаг даргаас олгох "Шагналын журам"-ыг шинэчлэн хавсралт ёсоор баталсугай.
2. Аймгийн Засаг даргын шагнал "Жуух" бичгээр шагнагдсан иргэдийн дагалдах мөнгөн шагнаалд зарцуулах хөрөнгийг тухайн байгууллагын төсвийн хэмнэлт, өөрийн орлогоос гаргаж байхаар тогтоосугай.
3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2014 оны "Журам батлах тухай" а/485 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Г.ГАНБОЛД



011101503

Аймгийн Засаг даргын ... оны
12.дугаар сарын 11.ний өдрийн 2019
захирамжийн хавсралт
11788

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГААС ОЛГОХ ШАГНАЛЫН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулж, тодорхой амжилт гаргасан байгууллага, иргэдийг аймгийн хэмжээнд жил бүр шалгаруулан, шагнаж, урамшуулахад энэхүү журмын зорилго оршино.

Хоёр. Шагнал олгох болзол

2.1. Тухайн онд хамт олноосоо хөдөлмөрийн амжилтаараа шалгарч аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэхэд идэвх санаачлага, үр бүтээлтэй 10-аас доошгүй жил ажилласан тус аймгийн харьят болон уuguул иргэд, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлсэн, ажлын байр олноор бий болгосон, орон нутагт томоохон хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт хийсэн ажилтан, ажилчин, аж ахуйн нэгж байгууллагыг сонгон шалгаруулж тухайн оны "Аймгийн ... оны аварга ажилтан", "Аймгийн ... оны тэргүүний байгууллага"-аар шалгаруулна.Үүнд:

2.1.1. Аймгийн ... оны аварга ажилтан:

Төрийн захиргаа, нийгмийн салбар, үйлдвэр, хөдөө аж ахуй, дэд бүтэц, санхүү, нийгмийн хамгаалал, хууль сахиулах болон хууль хяналт, худалдаа, үйлчилгээ, соёл, урлаг, спорт, аялал жуулчлалын байгууллагын ажилтан, ажилчдаас шалгаруулж "Аймгийн аварга ажилтан" цол, тэмдгээр шагнана.

2.1.2. "Аймгийн ... оны тэргүүний байгууллага"

Сүүлийн 3 жил дараалан хамт олны өмнө тавигдсан үндсэн ажил үйлчилгээ, үйлчилгээний анар, чанарын өндөр үзүүлэлтээр өсгөн биелүүлсэн, иргэдэд хөнгөн шуурхай, хүнд суртал чирэгдэлгүй үйлчилсэн, шинэ техник, технологи нэвтрүүлсэн, ажлын байр олноор бий болгосон, орон нутгийн хөгжилд томоохон хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт хийж хувь нэмэр оруулсан хамт олныг "Аймгийн ... оны тэргүүний байгууллага"-аар шалгаруулна.

2.2. "Хүндэт дэвтэр"-т бичих

Ажил хөдөлмөрийн өндөр амжилт гарган Монгол Улсын баатар, Хөдөлмөрийн баатар, төрийн шагнал, гавьяат цол хүртсэн, аймгийн "Хүндэт иргэн"-ээр өргөмжлөгдсөн иргэн болон нийгмийн тодорхой нэг салбарын хөгжилд онцгой гавьяа байгуулсан иргэнийг тус тус аймгийн "Хүндэт дэвтэр"-т бичиж алдаршуулна.

2.3. Аймгийн Засаг даргын "Жуух бичиг"

Байгууллага, салбарын ой, бусад тэмдэглэлт өдрийг тохиолдуулан аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэхэд идэвх санаачилга, үр бүтээлтэй 5-аас доошгүй жил ажиллаж хөдөлмөрийн амжилт гаргасан иргэнийг аймгийн Засаг даргын "Жуух бичиг"-ээр шагнана.

2.4. "Аймгийн аварга малчин", "Аймгийн аварга саальчин", "Аварга тариаланч", "Аймгийн шилдэг фермер"

2.4.1. Тухайн онд мал сүргээ өсгөн бойжуулж, малаас авах ашиг шимиин даалгаврыг хамгийн өндөр төвшинд биелүүлж, амьжиргааны баталгаажих доод

төвшингөөс доогуур орлоготой иргэдийг дэмжин малжуулсан “Аймгийн аварга малчин”, “Аймгийн аварга саальчин” шалгаруулна.

2.4.1.1 “Аймгийн аварга малчин”, “Аймгийн аварга саальчин” дараах шалгуур хангасан байна.

а/ малын индексжуулсэн даатгалд малаа хамруулж, эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэл төлсөн байх;

б/ мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэхдээ залуу малчин, шинээр мал маллаж байгаа иргэн, өрхөд мал маллах туршлагаа зааж сурган туслах малчинтай, цагаан идээ боловсруулах зэргээр ажлын байрыг нэмэгдүүлэх болон орон нутагтаа тодорхой хувь нэмэр оруулсан байх;

в/ мал сүргээ мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд тогмол бүрэн хамруулж, сүүлийн жилд гоц халдварт өвчин гаралгүй, малын зүй бусын хорогдолгүй, сүргийн бүтцийг зохистой түвшинд хангасан, бодод шилжүүлснээр 100-аас доошгүй толгой малтай байх;

г/ мэргэжлийн байгууллагаас ангилалт хийж удам гарвал, ашиг шимиийг нь тогтоосон, стандартын шаардлага хангасан малыг үржилд ашигладаг, малаа сумын Хөдөө аж ахуйн тасгийн бүртгэлд хамруулсан байх;

д/ өөрийн эзэмшлийн өвөлжөө, хаваржаа, малын хашаа, худаг, уст цэгтэй байх;

е/ сүрэгт эзлэх хээлтэгч мал нь бог малд 55, бод малд 40-өөс доошгүй хувьд хүрсэн, эр, сувай малыг эдийн засгийн эргэлтэд оруулдаг байх;

ж/ нутаглаж байгаа өөрийн газрынхаа бэлчээрийн даацад малын тоог тохируулан сумын бэлчээрийн менежментийн төлөвлөгөөний дагуу бэлчээрийг хуваарийн дагуу ашиглах, отор хийх, сэлгэн өнжөөх зэргээр бэлчээр хамгаалах арга хэмжээ авдаг байх;

з/ ойт хээрийн бүсэд хонин толгойд шилжүүлснээр ой хээрийн бүсэд нэг малд 40 кг, тал хээрийн бүсэд 30 кг,.govийн бүсэд 5 кг-аас доошгүй өвстэй тэнцэхүйц хадлан, гар тэжээл, өвсөн дарш, хүчит тэжээлийг жил бүр бэлтгэж нөөцөлсөн байх;

к/ “Аймгийн аварга саальчин” дээрх шалгуурыг хангахын зэрэгцээ зөвхөн уламжлалт аргаар мал малладаг, төллөсөн бүх хээлтэгчийг саалинд хамруулж, нийт саасан сүүний хэмжээ жил дараалан өссөн байх ба саасан сүү, боловсруулсан цагаан идээ, бүтээгдэхүүнээ зах зээлд борлуулах сүлжээтэй, арга ажиллагаагаа зааж сургасан шавь саальчинтай болсон байх;

л/ “Аймгийн аварга малчин”-аар шалгараах малчид нь “Сумын аварга малчин”-аар шалгараад 2-оос доошгүй жил болсон байх.

2.4.1.2. Тухайн жилийн эцсийн мал тооллогын дүнгээр 200-аас дээш үхэр тоолуулсан мөн үхэр сүргээ 3 жил дараалан өсгөж өмнөх амжилтаяа бататгасан “Аймгийн аварга малчин”, хамгийн олон тэмээ тоолуулсан, ботго бойжуулсан үзүүлэлтийг хангасан тэмээчин өрхийг “Аймгийн аварга малчин”-аар шалгаруулах бөгөөд дээрх аварга малчны шалгуур хамаарахгүй

2.4.2. Тариалангийн үйлдвэрлэлийн технологийг нарийн чанд мөрдөж, га-гаас авах ургацын хэмжээгээр шалгарсан, аймаг орны нийгэм, эдийн засгийн өсөлтийг хангахад бодитой хувь нэмэр оруулсан “Аймгийн аварга тариаланч” шалгаруулна.

2.4.2.1. “Аймгийн аварга тариаланч” дараах шалгуур хангасан байна.

а/ аж ахуйн нэгж байгууллага 200 га-аас дээш талбайд үр тариа, 5 га-аас дээш талбайд төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, 10-аас дээш га-д малын тэжээл, иргэн 50 га-д үр тариа, 0.2 га-д төмс, хүнсний ногоо жимс жимсгэнэ, тариалж жил бүр тогтвортой ургац авсан байх; /Үр тариа тариалаагүй суманд тус заалт хамрагдахгүй/

б/ төмс, хүнсний ногоог 100 хувь усалгаатай тариалсан байх;

в/ үр тарианы га-ийн дундаж ургац усалгаатай талбайд 15 центнерээс доошгүй, усалгаагүй талбайд 12 центерээс доошгүй, малын тэжээл 30-аас доошгүй центнер хураан авсан байх;

г/ га-аас хураан авах төмсний ургац аймгийн дундаж га-ийн ургацаас 20 хувиас дээш, хүнсний ногооны ургац 20 хувиас дээш центнер ургац хураан авсан байх;

д/ хөрс хамгаалах болон хог ургамалтай тэмцэх ажилд системтэй арга хэмжээг авч хэрэгжүүлсэн, үйлдвэрлэлээ эрчимжүүлсэн, техникийн шинэчлэл хийсэн байх;

е/ аж ахуйн нэгж, иргэд өөрийн эзэмшсэн талбайгаа сүүлийн 3 жил бүрэн ашиглаж, татвар хураамжаа хугацаанд нь төлсөн байх;

ж/ өөрийн үтрэм, үрийн агуулах, төмс хүнсний ногооны зоорьтой, сайн чанарын үрээр тариалалт хийсэн байх;

з/ аж ахуйн нэгж байгууллага нь үйлдвэрлэлийн осол гаргаагүй, хуулийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж, ажлын байр нэмэгдүүлж ядуурлыг бууруулах болон орон нутгийнхаа хөгжилд тодорхой хувь нэмэр оруулсан байх.

2.4.3. Хөдөө аж ахуйг эрчимжүүлэн, нэг мал, амьтнаас ашиглах ашиг шимиийн гарцыг нэмэгдүүлж, хүн амыг хүнсний цэвэр, аюулгүй бүтээгдэхүүнээр хангахад саначилгатай ажилласан “Аймгийн шилдэг фермер” шалгаруулна.

2.4.3.1. “Аймгийн шилдэг фермер” дараах шалгуур хангасан байна.

а/ фермерийн аж ахуй нь 3-аас доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан, хашаа байр, материаллаг баазаар хангагдсан, өөрийн талбайд хэрэгцээт тэжээлээ тариалдаг байх;

б/ үйлдвэрлэсэн сүү, мах, өндөг, зөгийн бал зэрэг бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь 3 жил дараалан өссөн, түүнийгээ орон нутгийн зах зээлд нийлүүлж, төв суурин газруудын хүн амыг эрүүл, аюулгүй хүнсээр хангахад тодорхой хувь нэмэр оруулсан байх;

в/ фермерийн аж ахуйн үхэр, гахай, шувуу, туулай, зөгий зэрэг мал амьтдыг мал эмнэлгийн үзлэг шинжилгээнд тогтмол хамруулж, халдварт, паразит өвчинөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд бүрэн хамруулан эрүүл мал, амьтан өсгөсөн байх;

г/ мал, амьтнаа даатгалд хамруулан холбогдох хууль тогтоомжийн дагуу татвар хураамжийг тогтмол төлсөн байх;

д/ сүүний чиглэлийн фермерийн аж ахуй нь 15-аас доошгүй үнээ, эсхүл 100-аас доошгүй ямаатай, жилд дунджаар нэг үнээнээс 2000, 1 ямаанаас 200 литрээс доошгүй сүү сааж, Мал эмнэлэгийн ариун цэврийн шинжилгээтэй сүүг иргэдийн хэрэгцээнд нийлүүлж, тэжээлийн цех, агуулахтай байх;

е/ өндөгний чиглэлийн фермерийн аж ахуй нь 1200-аас доошгүй өндөглөгчтэй, нэг өндөглөгчөөс жилд дунджаар 180-аас доошгүй өндөг авч, Мал эмнэлэгийн ариун цэврийн шинжилгээтэй баталгаат өндөгийг иргэдийн хэрэгцээнд нийлүүлсэн байх;

ж/ гахайн фермерийн аж ахуй нь 5-аас доошгүй үндсэн мэгжтэй, нэг мэгжнээс 10-аас доошгүй торой бойжуулж, 4.0 тонноос доошгүй мах үйлдвэрлэж, зах зээлд борлуулсан байх;

з/ туулайн фермерийн аж ахуй нь 200-аас доошгүй эм туулайтай, жилд дунджаар 0.5 тонноос доошгүй мах үйлдвэрлэсэн байх;

и/ зөгийн фермерийн аж ахуй нь 10-аас доошгүй бүл зөгийтэй, жилд дунджаар 150 кг-аас доошгүй бал хураан авч, зах зээлд борлуулсан байх.

2.5. “Аймгийн манлай малчин” шалгаруулах

Жил бүр таван төрөлд малаараа тэргүүлсэн малчинг манлай малчнаар шалгаруулна.

2.6. Дурсгалын зүйл гардуулах

Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх, иргэдийн тав тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, гадаад харилцааг өргөжүүлэн хөгжүүлэх, шинжлэх ухааны салбарт шинэ нээлт, бүтээл тууривах, дэвшилтэт тэргүүний техник, технологи нутагшуулах, орон нутгийн бүтээн байгуулалтад томоохон хөрөнгө оруулалт хийж, аймаг орон нутгийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулсан Монгол Улсын иргэн, гадаадын иргэнд аймгийн Засаг дарга дурсгалын зүйл гардуулна.

Гурав. Аймгийн шагнал олгоход баримтлах зарчим, шагнах асуудлыг шийдвэрлэх

3.1. Аймгийн шагналаар шагнахдаа доорх зарчмыг баримтална.

3.1.1. Аймгийн аварга малчин: Жил бүр аймгийн аварга малчин өрхөөр журамд заасан шалгуурыг хангасан малчныг шалгаруулж шагнана.

3.1.2. Аймгийн аварга тариаланч: Жил бүр аймгийн тэргүүний тариаланчаар 5 хүртэл хүнийг шалгаруулж шагнана.

3.1.3. Аймгийн аварга ажилтан: Тухайн жилд ажил хөдөлмөр, мэргэжлийн ур чадвараараа тодорч амжилттай ажилласан, аймаг, сумын хөгжилд тодорхой хувь нэмэр оруулсан нутгийн захиргаа, хууль хяналт, эдийн засаг, нийгмийн зэрэг салбаруудаас 10 хүртэл иргэнийг шалгаруулж шагнана.

3.1.4. Аймгийн ... оны тэргүүний байгууллага: Аймгийн албан байгууллага, аж ахуйн нэгжүүдийн тухайн жилийн төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны үзүүлэлтийн чанарыг харгалзан аймгийн Засаг даргын Тамгын газрын саналыг үндэслэн 3 хүртэл байгууллага, хамт олныг шалгаруулж шагнана.

3.1.5. “Аймгийн аварга саальчин”: Жил бүр аймгийн аварга саальчнаар журамд заасан шалгуурыг хангасан 5 хүртэл хүнийг шалгаруулж шагнана.

3.2 Шагналд нэр дэвшүүлэх, тодорхойлох

3.2.1. Шагналд нэр дэвшигч нь энэ журмын хоёрдугаар хэсэгт заасан болзлыг хангасан байна.

3.2.2. Нэр дэвшүүлэгч байгууллага нь энэхүү журмын хоёрдугаар хэсэгт заасан болзол хангасан иргэнийг жилд 1 удаа шагналд нэр дэвшүүлнэ.

3.2.3. Аймгийн Засаг даргын энэ журмын 2.5-д дурдсан шагналыг бусад төрийн дээд болон салбарын шагналтай давхардуулан олгохгүй байх зарчмыг баримтална.

3.2.4. Шагналд нэр дэвшүүлэх санаачилгыг тухайн нэр дэвшигчийн харьяалж буй үндсэн байгууллага гаргаж, холбогдох материалыг бүрдүүлэн энэхүү журмын 3.2.7-д заасан тэмдэглэлт хугацаанаас 15-аас доошгүй хоногийн өмнө аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны, удирдлагын хэлтэст ирүүлнэ.

3.2.5. Шагналд нэр дэвшигчийн талаар дараах материалыг бүрдүүлнэ.

а/ Батлагдсан загварын дагуу үйлдсэн анкет

б/ Ажил, байдлын тодорхойлолт /Аймгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд оруулсан сүүлийн 3 жилийн ажлын үзүүлэлтийг хавсаргасан байх/

в/ Хамт олны хурлаар хэлэлцсэн тэмдэглэл

г/ Байгууллага, аж ахуйн нэгжийн дэмжсэн албан бичиг

д/ Урьд нь авч байсан аймгийн Засаг даргын шагналын үнэмлэхний хуулбар

е/ Хөдөө аж ахуйн салбараас аймгийн аваргад нэр дэвшигчдийн анкет, ажлын үзүүлэлт, тодорхойлолтын баталгааны загварыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын тушаалаар батлана.

Ажил, байдлын тодорхойлолтод шагнуулах үндэслэл, ажлын амжилтыг үнэн зөв, товч, тодорхой тусгасан байх бөгөөд урьд нь авч байсан шагналд дахин нэр дэвшүүлэхгүй байх болон өмнө авсан шагналаас бууруулахгүй байх зарчмыг баримтална.

3.2.6. Аймгийн Засаг даргын шагналд тодорхойлох шагнал хоорондын хугацаа 3-аас дээш жил байна. Онцгой гавьяа байгуулсан тохиолдолд энэ хугацаа хамаарахгүй.

3.2.7. Аймгийн Засаг даргын шагналыг жил бүрийн Үндэсний Их баяр наадам, аймаг байгуулагдсан өдөр, Монгол улс тунхагласны баяр, Үндсэн хууль баталсан өдөр, Сар шинийн баяр буюу тэмдэглэлт өдрийг тохиолдуулан олгоно. Онцгой гавьяа байгуулсан тохиолдолд энэ хугацаа хамаарахгүй.

3.2.8. Аймгийн Засаг даргын Тамгын газарт Хүний нөөцийн асуудал хариуцсан албан тушаалтан энэхүү журмын 3.2.5-д заагдсан болзлын шаардлага хангасан

шагналын материалыг нягтлан үзэж хавсралтаар батлагдсан маягтын дагуу боловсруулан нэгтгэж Төрийн захиргааны, удирдлагын хэлтсийн даргаар хянуулан аймгийн Засаг даргад уламжилна.

3.2.9. Шагналын бичиг баримтыг хуурамчаар бүрдүүлсэн тохиолдолд шагнал олгохгүй ба дараагийн 3 жилд шагналд нэр дэвшүүлэхгүй.

Дөрөв. Шагнах асуудлыг шийдвэрлэх

4.1. Шагналд нэр дэвшигчийн материалыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны, удирдлагын хэлтэс хүлээн авч, холбогдох журмын дагуу хянан боловсруулж тухайн байгууллагыг харьяалах хэлтсээс саналыг нь авч, аймгийн Засаг даргад уламжлан ажлын 7-10 хоногийн дотор шийдвэрлүүлнэ.

4.2. Боловсрол, эрүүл мэнд зэрэг олон албан хаагч, ажиллагсадтай салбарын нэгж байгууллагуудын шагналд нэр дэвшүүлсэн албан хаагчдын материалыг аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн газар болон Эрүүл мэндийн газрын даргын албан бичгийг шагналын материалын хамт Төрийн захиргааны, удирдлагын хэлтэст ирүүлнэ.

4.3. Хөдөө аж ахуйн салбараас аймгийн аваргын шагналд нэр дэвшигчдийн материалыг сумдаас Хүнс, хөдөө аж ахуй газар авч нэгтгэн аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст ирүүлнэ. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс хянаж, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ.

4.4. Бүрдэл дутуу материалыг ирүүлсэн тохиолдолд хүлээн авахгүй бөгөөд үүнээс үүсэх үр дагаврыг аймгийн Засаг даргын Тамгын газар хариуцахгүй.

Тав. Шагналын дагалдах мөнгөн шагнал, баталгаа

5.1. "Аймгийн аварга ажилтан"-аар шалгарахад өргөмжлөл, 200.000 /Хоёр зуун мянган/ төгрөг дагалдана.

5.2. Хүндэт дэвтэрт бичигдсэн иргэнд баталгаа болгон гэрчилгээ олгох ба 75.0 /Далан таван мянган/ төгрөг дагалдана.

5.3. Аймгийн Засаг даргын "Жуух бичиг"-ээр шагнахад дагалдах 30.000 /Гучин мянган/ төгрөгийг шагналд тодорхойлсон байгууллага олгоно. Харин тодорхой харьяалах байгууллагагүй иргэн, ахmad настны шагналын мөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангаас гаргана.

5.4. "Аймгийн аварга малчин "-аар шалгарсан өрхийн эхнэр, нөхөрт энгэрийн тэмдэг, үнэмлэх гардуулж 400000 /Дөрвөн зуун мянга/ төгрөг дагалдана.

5.5. "Аймгийн аварга тариаланч"-д энгэрийн тэмдэг, үнэмлэх, 200000 /Хоёр зуун мянган/ төгрөг дагалдана.

5.6. "Аймгийн оны тэргүүний байгууллага"-д Өргөмжлөл, 300000 /Гурван зуун мянган/ төгрөг дагалдана.

5.7. "Аймгийн шилдэг фермер"-д Өргөмжлөл, 200000 /Хоёр зуун мянган/ төгрөг дагалдана.

5.8. Энэ журмын 2.7-д заасан аймгийн Засаг даргын дурсгалын зүйл нь 200000 мянган хүртэл төгрөгийн үнэтэй байж болно.

5.9. "Аймгийн манлай малчин"-д Өргөмжлөл, 200000 /Хоёр зуун мянга/ төгрөгийн дурсгалын зүйл дагалдана.

5.10. "Аймгийн аварга саальчин"-д энгэрийн тэмдэг, үнэмлэх, 400000 /Дөрвөн зуун мянга/ төгрөг дагалдана.

Зургаа. Шагналын мэдээллийн сан

6.1. Аймгийн ЗДТГ-ны шагнагдсан ажилтнуудын мэдээллийн сантай байх ба санг шагналын төрөл, олгосон хугацаа, оноор төрөлжүүлсэн байна.

6.2. Мэдээллийн сангийн бүрдүүлэлт, баяжилт хөдөлгөөнийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн хариуцна.

6.3. Аймгийн сумд болон төрийн, төрийн бус байгууллагууд нь ажилтнуудын шагналын бүртгэл, мэдээллийн сантай байх ба байгууллагын хүний нөөцийн менежер нь шинээр шагнагдах хүмүүсийн шагналын судалгааг гаргаж дотоодын хяналт тавина.

Долоо. Хариуцлага

7.1. Шагналтай холбоотой бичиг баримтыг хуурамчаар бүрдүүлж ирүүлсэн, нэгтгэсэн болон хянасан албан тушаалтныг шаардлагатай тохиолдолд аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж хариуцлага тооцно.

Найм. Аймгийн Засаг даргаас олгох шагналын тодорхойлолт

8.1. "Аймгийн аварга ажилтан" тэмдэг

"Аймгийн аварга ажилтан" тэмдэг нь эх бие болон зүүлт гэсэн хоёр хэсгээс бүрдэнэ. Эх биеийн хэсэг нь 30-40 мм-ийн голч бүхий хэмжээтэй тойрог хэлбэртэй байх бөгөөд тухайн орон нутгийн байгаль, түүхэн замналын онцлогийг бэлгэдсэн дүрслэлтэй байх бөгөөд "Аймгийн аварга ажилтан" тэмдгийн оноосон нэрийг монгол бичгээр бичсэн байна.

Тэмдгийн зүүлтийн хэсэг нь 25 мм урт, 15 мм өргөн, доод талдаа шаталсан давхарга хэлбэртэй байна. Тэмдгийн зузаан нь 2 мм байна.

Тэмдгийн тухайлсан загварыг аймгийн Засаг дарга батална. "Аймгийн аварга ажилтан" тэмдгээр шагнагдагсдад хувийн дугаар бүхий үнэмлэх олгоно.

8.2. "Аймгийн аварга малчин"-ы үнэмлэх, тэмдэг

"Аймгийн аварга малчин өрх"-ийн үнэмлэх нь улаан өнгийн хавтастай байх бөгөөд нүүрэн талд нь "соёмбо" тэмдгийг дүрсэлж түүний доод хэсэгт нь "Өвөрхангай аймгийн аварга малчны үнэмлэх" гэж бичиж хэвлэсэн байна.

Үнэмлэхний доторх хуудас нь түмэн насан хээ бүхий бор шаргал дэвсгэртэй байх бөгөөд тухайн орон нутгийн байгаль, 5 хошуу малын зураг, "Өвөрхангай аймгийн аварга малчин", дугаар, шагнагдсан тухай шийдвэрийн товч утгыг бичиж аймгийн Засаг дарга гарын үсэг зурахаар нэрийг нь хэвлэсэн байна.

"Аймгийн аварга малчин"-ийн тэмдэг нь эх бие болон зүүлт хэсгээс бүрдэх бөгөөд эх биеийн хэсэг нь 30 мм-ийн голч бүхий хэмжээтэй тойрог байна. Эх биеийн хэсэгт нь байгалийн болон 5 хошуу малын зургийг товоилгож дүрслэх бөгөөд "Аймгийн аварга малчин өрх" гэж монгол бичгээр бичнэ.

8.3. "Аймгийн аварга тариаланч"-ийн үнэмлэх, тэмдэг

"Аймгийн аварга тариаланч"-ийн үнэмлэх нь улаан өнгийн хавтастай байх бөгөөд нүүрэн талд нь "соёмбо"-ыг дүрсэлж түүний доод хэсэгт "Өвөрхангай аймгийн аварга тариаланч" гэж бичиж хэвлэсэн байна.

Үнэмлэхний доторх хуудас нь түмэн насан хээ бүхий бор шаргал дэвсгэртэй байх бөгөөд тухайн орон нутгийн байгаль, газар тариаланг харуулсан зураг, "Өвөрхангай аймгийн аварга тариаланч", дугаар, шагнагдсан тухай шийдвэрийн товч утгыг бичиж аймгийн Засаг дарга гарын үсэг зурахаар хэвлэсэн байна.

"Аймгийн аварга тариаланч"-ийн тэмдэг нь 30 мм-ийн голч бүхий хэмжээтэй тойрог байх бөгөөд ногоон /газар/ өнгийн дэвсгэр дээр тариан түрүүг дүрсэлж, "Өвөрхангай аймгийн аварга тариаланч" гэж бичсэн байна.

8.4. "Аймгийн ... оны тэргүүний байгууллага"-ын үнэмлэх

"Аймгийн ... оны тэргүүний байгууллага"-ын үнэмлэх нь зөөлөвч бүхий улаан хавтастай байх бөгөөд хавтасны нүүрэн талд төрийн сүлдийг алтадмал шаргал өнгөөр дүрсэлж доод талд нь "Өвөрхангай аймгийн ... оны тэргүүний байгууллага" гэж бичиж хэвлэсэн байна.

"Аймгийн ... оны тэргүүний байгууллага"-ын үнэмлэхний доторхи хуудсанд төрийн сүлд, тухайн аймгийн онцлог утга бүхий зураг, аймгийн Засаг дарга гарын үсэг зурахаар нэрийг нь хэвлэсэн байна.

8.5. Аймгийн Засаг даргын "Жуух бичиг"

Аймгийн Засаг даргын "Жуух бичиг" нь улаан өнгийн хавтастай байх бөгөөд хавтасны нүүрэн талд нь "соёмбо"-ыг дүрсэлж, доод талд нь "Өвөрхангай аймгийн Засаг даргын жуух бичиг" гэж бичнэ.

Аймгийн Засаг даргын "Жуух бичиг"-ийн доторх хуудсанд "соёмбо", тухайн орон нутгийн онцлогийг илтгэсэн зураг болон шагнагдсан тухай товч бичиглэл, аймгийн Засаг дарга гарын үсэг зурахаар нэрийг нь хэвлэсэн байна.

8.6. "Аймгийн аварга саальчин"-ы үнэмлэх, тэмдэг

"Аймгийн аварга саальчин"-ы үнэмлэх нь улаан өнгийн хавтастай байх бөгөөд нүүрэн талд нь "соёмбо" тэмдгийг дүрсэлж түүний доод хэсэгт нь "Өвөрхангай аймгийн аварга саальчны үнэмлэх" гэж бичиж хэвлэсэн байна.

Үнэмлэхний доторх хуудас нь түмэн насан хээ бүхий бор шаргал дэвсгэртэй байх бөгөөд тухайн орон нутгийн байгаль, 5 хошуу малын зураг, "Өвөрхангай аймгийн аварга саальчин", дугаар, шагнагдсан тухай шийдвэрийн товч утгыг бичиж аймгийн Засаг дарга гарын үсэг зурахаар нэрийг нь хэвлэсэн байна.

"Аймгийн аварга саальчин"-ийн тэмдэг нь эх бие болон зүүлт хэсгээс бүрдэх бөгөөд эх биеийн хэсэг нь 30 мм-ийн голч бүхий хэмжээтэй тойрог байна. Эх биеийн хэсэгт нь байгалийн болон 5 хошуу эх мал, сүүн цацлын зургийг товоилгож дүрслэх бөгөөд "Аймгийн аварга саальчин" гэж монгол бичгээр бичнэ.